Монгол Улс: Институцийн өөрчлөлт хийх замаар эрдэс баялгийн менежментийг сайжруулах төсөл

Сэтгүүл: 2017 оны 7 сар

ТӨСЛИЙН ТУХАЙ

MERIT төсөл нь 2016-2022 оны хооронд нийт 6 жилийн хугацаанд Монгол улсад хэрэгжих бөгөөд олборлох салбарыг үр дүнтэй удирдахад төрийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх замаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгоход хувь нэмрээ оруулах зорилготой. Төслийн хоёр дахь удаагийн товхимолд 2017 оны 1 сараас 6 сар хүртэл хугацаанд төслөөс хэрэгжүүлсэн үйл ажиллагааны мэдээллийг оруулаа.

MERIT төсөл Дорнод аймагт хэрэгжиж эхлэв

Нутгийн захиргааны байгууллагын чадавхи бэхжүүлэх болон олборлох үйлдвэрлэлээс орж ирэх орлогыг үр дүнтэй удирдах, үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр MERIT төсөл Дорнод аймагтай хамтран ажиллана. Аймгийн үйл ажиллагааны төлөвлөлт, хөтөлбөрийг хянах, эрэмбэлэх болон уурхайгаас орон нутагт бий болгох орлогын урсгалын зураглал боловсруулах ажлууд хийгдэж эхлээд байна.



MERIT-н Техникийн зөвлөх Бренда Воучер

Олборлох үйлдвэрлэлийн мэдээллийг нэгтгэн боловсруулах, мөн аймгийн хөгжлийн ойрын болон хэтийн зорилтуудыг нягтлах, хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр хоёр Техникийн зөвлөх Аймгийн Засаг даргын багтай хамтран ажиллаж, зөвлөмжөөр хангав.

Дорнод аймгийн удирдлагын баг одоогоор аймгийн түвшинд тулгамдсан асуудлуудыг эрэмбэлэх, тэдгээрийг шийдвэрлэх зорилго, зорилтыг тодорхойлох, мөн хэрэгжилтийн үр дүнд хяналт үнэлгээ хийхээр ажиллаж байна. Нийт 60 мэргэжилтнийг хамруулан нэг өдрийн сургалт семинар зохион байгуулж, нэн тэргүүний ач холбогдол бүхий асуудлуудыг үнэлэх, хэрэгжилтийг хянах, зохицуулалтын хангах талаар багаар ажиллан, нэгдсэн ойлголт авав. Аймгийн захиргааны ажилтнууд тус сургалтаас олж авсан мэдлэгийг ирэх жилийн ажлын төлөвлөгөө боловсруулахад ашиглах боломжтой болсон.

Дорнод аймгийн олборлох салбарын эдийн засгийн болон санхүүгийн харилцан хамаарлыг үнэлэх судалгааг хийсэн бөгөөд тус судалгааны үр дүн, мэдээллийг оролцогч талуудтай хуваалцахаар төлөвлөж байна. Тус судалгааны үр дүнг түшиглэн MERIT болон Дорнод аймгийн хамтарсан санаачлагууд хэрэгжих болно.

Үр дүнд суурилсан менежментийг сайжруулах талаар зөвлөх үйлчилгээг Хамтрагч байгууллагад үзүүлэв

2017 оны 2 сард MERIT-н Техникийн зөвлөх БОАЖЯ-нд дөрвөн долоо хоног ажиллан, яамны түвшний хяналт үнэлгээний системтэй танилцан дүгнэлт хийж, цаашид чадавхижуулах чиглэлээр зөвлөмж боловсруулсан.

Тус зөвлөмжийн дагуу Үр дүнд суурилсан менежмент болон хяналт, үнэлгээний системийг сайжруулах яамны хэрэгцээг тодорхойлж, чадавхижуулах сургалтуудыг төлөвлөх, эхлүүлэх болсон.

Энэ хүрээнд хэд хэдэн чадавхижуулах сургалтуудыг цуврал байдлаар зохион байгуулахаар төлөвлөсөн бөгөөд эхний ээлжийн сургалтыг 2017 оны 9 сард хийхээр төлөвлөөд байна.

Багийн ажиллагаа, цагийн менежментийн сургалтыг хамтрагч байгууллагуудад хийв

Хамтрагч байгууллагуудын хэрэгцээ, шаардлагыг үндэслэн АМГТГ, ШУТИС-ийн ГУУС болон ГГХ зэрэг гурван түнш байгууллагад багийн ажиллагаа, цагийн менежментийн сургалтуудыг MERIT амжилттай зохион байгуулаа.

Энэхүү сургалтыг 5 сард хийсэн бөгөөд оролцогчид багийн ажлууд, хэлэлцүүлэгт идэвхитэй оролцон, багаар ажиллах төлөвлөгөө хамтдаа боловсруулж байсан нь сургалтын агуулгыг оролцогчид сайн ойлгосныг илтгэж байв. Сургалтанд оролцогчид шинээр сурсан мэдлэгээ цаашдын ажилдаа ашиглах эрмэлзэлтэй буйгаа илэрхийлж байсанд сургалтын ач холбогдол оршино.

Боловсон хүчнийг хөгжүүлэх буюу тухайн ажлын байранд шаардагдах манлайлал болон баг бүрдүүлэх ур чадварыг хөгжүүлэх чиглэлээр дараа дараагийн сургалтын арга хэмжээг хамтрагч байгууллагуудтай зөвлөлдсөний үндсэн дээр цаашид үргэлжлүүлэх юм.



АМГТГ дээр зохион байгуулагдсан сургалт

Товч үгийн тайлбар:

БОАЖЯ- Байгаль орчин, аялал жуулчлалын яам
АМГТГ – Ашигт малтмал, газрын тосны газар
ГГХ – Газарзүй, геоэкологийн хүрээлэн
ШУТИС-ийн ГУУС – Шинжлэх ухаан, техникийн их сургуулийн Геологи, уул уурхайн сургууль



ШУТИС-ийн ГУУС дээр зохион байгуулагдсан сургалт

Чадавхи хөгжүүлэх төлөвлөгөөнд хамтрагч байгуулагатай гарын үзэг зурж баталгаажуулав

MERIT нь ШУТИС-ийн ГУУС-тай хамтран хэрэгжүүлэх Чадавхи хөгжүүлэх төлөвлөгөөнд 2017 оны 3 сарын 16-ны өдөр гарын үсэг зурлаа. Тус Чадавхи хөгжүүлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд ШУТИС-ийн ГУУС-ийн хүний нөөц, манлайлал, уурхайн менежментийн сургалтын хөтөлбөрүүд, тэдгээрийн магадлан итгэмжлэл, дадлагажигч хөтөлбөр мөн жендэрийн асуудлыг сайжруулах чиглэлээр хамтран ажиллах болно.



ШУТИС-ийн ГУУС-тай чадавхи хөгжүүлэх төлөвлөгөөнд гарын үсэг зурах ёслол

Хамтрагч байгууллагын хүний нөөцийн хэрэгцээний үнэлгээг хийв

Хүний нөөцөөр мэргэшсэн Техникийн зөвлөх 2017 оны 3 сард АМГТГ-д ажиллан, байгууллагын чадавхи, хүний нөөцийн менежментийг сайжруулахад туслалцаа үзүүлэх үүднээс хүний нөөцийн хөгжлийн хэрэгцээг үнэлэв. Энэхүү үнэлгээний үр дүнг түшиглэн АМГТГ ба MERIT хамтран цаашид байгууллагын үр ашгийг нэмэгдүүлэхэд тун чухал болох Хүний нөөцийн үр чадвар хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр санал нэгдэж, цогц сургалтуудыг төлөвлөөд байна.

Хүний нөөцийн үр чадвар хөгжүүлэх хөтөлбөр нь байгууллагын ажилтнуудыг үе шаттай, системтэй сургах цогц менежментийн хэрэгсэл болох юм.

Хөтөлбөрийн эхний ээлжинд ажлын байрны шинжилгээ хийхээр төлөвлөсний дагуу MERIT-н Техникийн зөвлөх АМГТГ-д байрлан, ажлын байрны тодорхойлолт, үр чадварын шалгуур үзүүлэлтүүдийг үнэлэх чиглэлээр холбогдох ажилтнуудыг чадавхижуулж ажиллав. Дараагийн шатанд Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөрийг боловсруулна.

Мэдээллийн портал үүсгэн байгуулах

Мэдээллийн портал үүсгэх ажил үргэлжлүүлэн хийгдэж байна. Цахим сургалтуудын модуль бүхий энэхүү Мэдээллийн порталыг ГГХ-д байршуулах бөгөөд MERIT-н Техникийн зөвлөхүүдийн боловсруулсан мэдээлэл, сургалтын материалууд, мөн түүнчлэн SESMIM төслөөс гаргасан материалуудыг ашиглана. Мэдээллийн порталыг байгуулах ажлыг хянах Удирдах хороог байгуулахаар төлөвлөж байна.

Цаашид хийгдэх сургалт, мэдээллийн материалуудыг тус портал дээр үргэжлүүлэн байршуулж, улам баяжуулах болно.

ШУТИС-н жендэрийн тэгш байдлын стратегийг нэвтрүүлэх

MERIT төсөл хэрэгжүүлэх үндсэн зарчим болох Жендэрийн тэгш байдлыг хангахад туслалцаа үзүүлэх талаар төслийн баримт бичиг, төлөвлөлтөнд тусгагдсан билээ. Иймээс Жендэрийн тэгш байдлыг дэмжих, жендэрийн талаар хамтрагч байгууллагуудын мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллаж байна.

Энэ хүрээнд жендэр болон хүний эрхийн асуудлаар мэргэшсэн Техникийн зөвлөх жендэрийн тэгш байдлын бодлогыг ШУТИС-ийн ГУУС-н бодлого, стратеги төлөвлөлтөнд тусгуулах талаар ажиллаж, холбогдох зөвлөмж боловсруулаа.

БОАЖЯ-нд Удирдлага мэдээллийн системийг суурилуулахад дэмжлэг үзүүлэв

БОАЖЯ-ны байгууллагын дотоод удирдлага, мэдээлэл хуваалцах ажлыг сайжруулах, хүний нөөцийн менежмент болон байгаль орчны зөвшөөрөл олголтыг цахимжуулах, түүнчлэн бусад төрийн байгууллагуудтай мэдээлэл солилцоог нэмэгдүүлэх үүднээс байгууллагын Удирдлагын мэдээллийн системийг худалдан авах, суурилуулахад туслалцаа үзүүлэв.

Төслийн удирдах хорооны хурал болов

MERIT төслийн бүх түнш байгууллагууд болон Канадын Гадаад Хэргийн Яамны төлөөлөл бүхий Удирдах хорооны хурлыг зохион байгуулсан бөгөөд тус хурлаар төслийн эхний жилийн үр дүнг танилцуулж, дараа жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцүүлж батлуулав.

Төслийн техникийн зөвлөхүүдээс бүрдсэн Зөвлөх хороо байгуулж 2017 болон 2018 онуудад хэрэгжүүлэх ажлуудыг хамтрагч байгууллага тус бүрийн хэрэгцээг үндэслэн тодорхойлов. Тус Хорооны зорилго нь төсөл хэрэгжилтийн сайн туршлагыг хамтрагч байгууллагуудад нэвтрүүлэх, төсөл хэрэгжилтийн үр дүн, уялдаа холбоог сайжруулах зорилготой.



Төслийн удирдах хорооны хоёр дахь уулзалт, 2017 оны 4 сарын 27-ны өдөр

Олборлох салбарт олон нийтийн хэлэлцүүлэг хийх удирдамж

Төсөл нь олборлох салбарт олон нийтийн хэлэлцүүлэг хийх удирдамжийг боловсруулж эхлээд байна.

Бидэнтэй холбоо барих:
3 давхар, Нейшнл Таймс Нюсь Тауер, Худалдааны гудамж, 1-р хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар – 15160, Монгол улс
Утас: (976) 7610-5000, Цахим хаяг: support@merit.mn,

Canada
Канадын Гадаад Хэргийн Яамны санхүүжилтээр MERIT төсөл хэрэгжиж байна.
CESOSACO
WUSC EUMC Education Changes the World